

SikaTop® Seal -109 TH

Полимераар сайжруулсан, цементэн суурьтай, уснаас хамгаалах уян түрхлэг

Бүтээгдэхүүний тодорхойлолт

SikaTop® Seal -109 TH нь цементэн суурьтай, 2-бүрэлдэхүүнт, полимераар баяжуулсан уян уснаас хамгаалах түрхлэг. Усны нэвчилтээс урьдчилан сэргийлэх үүднээс бетон болон шавардлага дээр түрхэж хэрэглэнэ.

Хэрэглээ:

Уснаас хамгаалах, хялгасан ан цавыг битүүмжлэх, нүүрстөрөгчийн давхар исэл (бетоны засварын ажил г.м), хөлдөлт, гэсгэлтийн бодис г.м хүчтэй элементүүдээс хамгаалах түрхлэг зорилгоор хэрэглэнэ.

Шинж чанар / Давуу талууд

- Хагарлыг битүүмжлэх чадвар сайтай
- Бэлэн хийц эдлэлүүдэд
- Холих болон хэрэглээ хялбар
- Өнхрүүш болон багсаар гүйцэтгэх боломжтой
- Бат бэх гадаргуутай барьцалдах чадвар сайтай
- Ус үл нэвтрүүлэх
- Хөлдөлд болон давсанд тэсвэр өндөртэй
- Нүүрстөрөгчийн давхар исэлийн нэвчилтийг бууруулна
- Хоргүй, цементтэй ижил
- Уян
- Хөлдөлд, гэсэлтэд тэсвэртэй (-10°C)
- Эдийн засгийн хувьд ашигтай

Хэлбэр

Харагдах байдал / Өнгө

А бүрэлдэхүүн : Цагаан өнгийн шингэн
В бүрэлдэхүүн : Сааралт өнгийн нунтаг
А+В (хольц) : Бараан саарал өнгийн зуурмаг

Савлагаа

36 кг сет (А бүрэлдэхүүн : 10 кг ба В бүрэлдэхүүн : 26 кг)

Хадгалалт

Хадгалах хугацаа

Сав баглаа боодол бүрэн бүтэн, хуурай сэрүүн орчинд хадгалах тохиолдолд үйлдвэрлэсэн огноогоос хойш 6 сар хадгална. Нарны шууд тусгалаас хамгаал.

Техникийн үзүүлэлт

Химийн суурь

Полимераар баяжуулсан портланд цемент

Нягт

1.7 – 1.9 кг/л (хольц)

Усны нэвчилтэд тэсвэртэй байдал

1.0 кг/м² ийн зарцуулалттай орчинд 6 цагийн турш нэвчилт үүсээгүй (DIN 1048: 5-р бүлэг)

Эсэргүүцэл

Гал эсэргүүцэх чадвар	Галын зэрэглэлийн түвшин A1, SikaTop® Seal -109 TH нь гал түймрийн аль ч үе шатад, ялангуяа бүрэн ассан гал түймрийг эсэргүүцэх чанаргүй (EN 13501-1)
-----------------------	---

Механик / Физик шинж чанарууд

Наалдамхайн хүч	> 0.7 N/mm ² (бетон дээр)
Суналтын бат бэх	> 1.0 MPa
Суналтын тасралт	> 32%
Хатуулаг чанар	> 59

Системийн мэдээлэл

Хэрэглээний дэлгэрэнгүй мэдээлэл

Зарцуулалт	Үе тус бүрт ойролцоогоор 1,0 кг/м ² зарцуулалтаар хамгийн багадаа 2 үе түрхлэгийн заавал хийх шаардлагатай. Усны нэвчилт ихтэй орчинд 1,0 кг/м ² зарцуулалтаар 3 үе түрхлэг хийж өгнө.
Гадаргуун чанар	Бетон, шавар, чулуун болон тоосгон өрлөгийн гадаргуу нь тос тосоолоос ангид цэвэр, элдэв сул хэсэггүй бат бөх байх байна.
Гадаргууг бэлдэх	Шингээгч гадаргуунд SikaTop Seal 108 бүтээгдэхүүний эхний үеийг түрхэхээс өмнө усаар сайтар норгох хэрэгтэй. Түрхлэгийн эхний үеийн гүйцэтгэлийг хийхээс өмнө гадаргуу дээрх тогтсон илүүдэл усыг цэвэрлэж авах шаардлагатай.

Орчны болон гадаргуун Температур	Хамгийн багадаа +8°C хэм
----------------------------------	--------------------------

Хэрэглээний зааврууд

Холих	Цэвэр хувинд бүтээгдэхүүний шингэн бүрэлдэхүүнийг хийгээд, дээрээс нь нунтаг бүрэлдэхүүнийг аажмаар нэмж зөөлөн хурдтай холигчоор сайтар хольж өгнө. Ердийн нөхцөлд А болон В бүрэлдэхүүнийг хольход өтгөн зуурмаг үүснэ.
-------	---

Гүйцэтгэл аргачлал / Багажууд

Тогтсон усгүй боловч чийглэж өгсөн гадаргуу дээр багс болон резинэн татагч ашиглан гадаргуу дээр эхний үеийг сайтар барьцалдуулан түрхэж өгнө.

Эхний үе давхрагыг ойролцоогоор 4 ~ 8 цаг (+20°C орчинд) бэхжүүлсэний дараа дараагийн үеийг түрхэнэ.

Хамрах талбай томтой гадаргууд SikaTop® Seal -109 TH -ийг тохирох шүршдэг холигч/насос ашиглах боломжтой.

Хагарал, хана/ шалны уулзвар г.м ачаалал, хөдөлгөөнтэй хэсгүүдэд нэмэлтээр эмжээрлэн түрхлэг хийхийг санал болгож байна.

Багажын цэвэрлэгээ	Гүйцэтгэлийн дараа багажуудаа усаар сайтар цэвэрлэх шаардлагатай. Учир нь хатаж бэхэжсэн материалыг зөвхөн механик аргаар цэвэрлэх боломжтой.
Нээлттэй байх хугацаа	~ 30 минут (+20°C орчинд)
Чухал санамжууд/ Хязгаарлалтууд	ихээр SikaTop® Seal 109 TH -г нэг үе давхрагад 2кг/м ² -с илүү бүү түрх. Барьцалдах чадварыг нэмэгдүүлэхийн тулд Sika Latex, цемент, ус болон нарийн элс бүхий зуурмагыг түрхэхийг санал болгож байна. Дэлгэрэнгүй мэдээллийг Sika Latex бүтээгдэхүүний танилцуулгаас үзэх боломжтой.
Арчилгаа	Тусгай төрлийн арчилгааны аргачлал шаардлагагүй ч гадаа хурц нартай болон хүчтэй салхитай орчинд гүйцэтгэлийг хийж байгаа тохиолдолд хамгаалах шаардлагатай.
Дүгнэлт	Энэхүү Техникийн зааварчилгаанд лабораторийн туршилтын үндсэн дээр батлагдсан техникийн үзүүлэлтүүд тусгагдсан ба бодит үзүүлэлтүүд нь тухайн нөхцөл байдалд өөр өөр байж болно гэдгийг анхаарна уу.
Эрүүл ахуй, аюулгүй Ажиллагааны мэдээлэл	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны болон физик, хими, байгаль орчны бусад нарийн мэдээллүүд бүтээгдэхүүний Эрүүл ахуй, Аюулгүй ажиллагааны зааварчилгаанд тусгагдсан болно.

Энэхүү маягтан дээр ерөнхий мэдээлэл нь Sika бүтээгдэхүүнийг хэрэглэх, хадгалах, ердийн нөхцөлд боловсруулалт хийх зааврыг агуулсан ба эдгээр мэдээлэл нь бүтээгдэхүүний талаар олж авсан туршилтын үр дүн, холбогдох мэдээлэл болон ойлголт дээрээ үндэслэсэн болно. Тиймээс зарим төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэх талбай, талбайн тухайн үеийн нөхцөлд зэрэгтэй уялдан харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг тул энэхүү мэдээллийн хуудас нь тухайн бүтээгдэхүүний баталгааны хуудас болж чадахгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Sika бүтээгдэхүүнийг өгөгдсөн зааврын дагуу хэрэглэсний улмаас үүсэж болзошгүй аливаа нэгэн асуудалтай холбоотой хууль эрх зүйн хариуцлага хүлээх боломжгүй юм. Бүтээгдэхүүний захиалгыг хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөл болон хүргэлтийн шаардлагын дагуу хүлээн авах ба бүтээгдхүүнтэй холбоотой өөрчлөлтийг хэрэглэгч нь үйлдвэрлэгчид албан ёсоор хүсэлт гаргасны үндсэн дээр авч болно.

Head Office
700/37 Moo 5 Bangpakong Industrial Park II,
Km.57 Bangna-Trad Rd., T.Klongtamhru,
Muang District, Cholburi 20000

Tel: +66 3821 4270-85
Fax: +66 3821 4286
E-mail: sikathai@th.sika.com
website: <http://www.sika.co.th>

Innovation & Consistency | since 1910